



“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн Гүйцэтгэх Захирлын
2023 оны 10 дугаар сарын 22-ний 14:00 дугаар тушаалын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Засгийн газрын дотоод үнэт цаас (цаашид “ЗГДҮЦ” гэх)-ны анхдагч зах зээлийн арилжааг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам” (цаашид “журам” гэх) -ын дагуу зохион байгуулахад энэхүү зааврыг баримтална.

Хоёр. ЗГДҮЦ-ны бүртгэл

- 2.1. Үнэт цаас гаргагч нь журамд заасны дагуу ЗГДҮЦ-ны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээг арилжаа эрхлэх байгууллагатай байгуулна.
- 2.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлт болон журамд заасны дагуу ЗГДҮЦ-ны арилжааны хуваарь, мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад ирүүлнэ.
- 2.3. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаас бүртгүүлэх хүсэлт болон энэ зааврын 2.1, 2.2-г тус тус үндэслэн ЗГДҮЦ-ыг бүртгэсэн тухай тушаал гаргаж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд мэдэгдэнэ.

Гурав. Арилжааны бэлтгэл хангах

- 3.1. Арилжаа эрхлэх байгууллага нь ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө дараах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. Арилжааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор шалгах;
 - 3.1.2. Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн ЗГДҮЦ-ны арилжааны хуваарь болон мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн www.mse.mn цахим хуудас, ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны www.bond.mse.mn /цаашид арилжааны систем гэх/ системээр дамжуулан ажлын гурваас доошгүй өдрийн өмнө мэдээлэх;
 - 3.1.3. Арилжаа эхлэхээс өмнө болон арилжааны дундуур арилжаанд оролцогчдод зайлшгүй мэдээлэх шаардлагатай эрх бүхий байгууллагын шийдвэр, цаг үеийн бусад мэдээллийг www.mse.mn цахим хуудас болон арилжааны системээр дамжуулан мэдээлэх;
- 3.2. Арилжаа эрхлэх байгууллага нь арилжаанд оролцогчдод арилжааны систем болон ЗГДҮЦ-ны талаарх сургалт, зөвлөгөөг зохион байгуулах, гарын

авлагаар хангах үйл ажиллагааг үнэт цаас гаргагчтай хамтран зохион байгуулж болно.


Дөрөв. ЗГДҮЦ-ны арилжааг зохион байгуулах

- 4.1. Арилжаа эрхлэх байгууллага нь арилжааны системийн найдвартай, шуурхай, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 4.2. ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг дараах 2 хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:
 - 4.2.1. “Ялгавартай үнэтэй арилжааны хэлбэр” гэж өрсөлдөөнт бус санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын арифметик жигнэсэн дундаж хүүгээр, өрсөлдөөнт санал нь тухайн шууд оролцогчийн ирүүлсэн хүүгийн саналаар биелэх ЗГДҮЦ-ны арилжааны хэлбэрийг;
 - 4.2.2. “Нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр” гэж өрсөлдөөнт бус санал болон өрсөлдөөнт санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр биелэх ЗГДҮЦ-ны арилжааны хэлбэрийг;
- 4.3. ЗГДҮЦ-ны арилжаанд оролцог нь өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналыг анхдагч зах зээлийн арилжааны системд долоо хоног бүрийн Лхагва гарагийн 11.00-12.00 цагийн хооронд оруулна.
- 4.4. Арилжаанд оролцогч нь арилжааны санал хүлээн авах хугацаанд үнэт цаас худалдан авах саналын хүү, үнэд өөрчлөлт оруулж, цуцалж болно.
- 4.5. Арилжаанд оролцогч нь ЗГДҮЦ-ны өрсөлдөөнт санал буюу хүү /өгөөж/-ийн саналыг үнэт цаас гаргагчийн тогтоосон нарийвчлалаар ирүүлнэ.
- 4.6. Арилжааны санал хүлээн авах хугацаанд нэг хөрөнгө оруулагч нь саналыг өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бусаар нэгэн зэрэг оруулж болно.
- 4.7. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг хөрөнгө оруулагчийн ЗГДҮЦ худалдан авах захиалгын дээд, доод хэмжээг заасан хязгаарлалтыг хийж болно.
- 4.8. Арилжаа эрхлэх байгууллага нь ЗГДҮЦ-ны арилжаанд оролцогчдоос ирүүлсэн нийт өрсөлдөөнт болон өрсөлдөөнт бус саналыг арилжааны санал хүлээн авах цаг дууссаны дараа үнэт цаас гаргагчид хургүүлнэ.
- 4.9. Арилжааг эрчим хүчиний түр saat, техник програм хангамжийн гэмтэл болон бусад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цуцалж болно.
- 4.10. Үнэт цаас гаргагч арилжааг цуцалсан тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан дараагийн арилжаа явагдах огноо, цагийг мэдэгдэнэ.


Тав. Арилжааны хуваарилалт хийх

- 5.1. Үнэт цаас гаргагч нь ЗГДҮЦ-ны арилжаа хийгдсэн тухайн өдөрт багтаан арилжааны хуваарилалтыг хийж баталгаажуулна.
- 5.2. Үнэт цаас гаргагч нь арилжаалсан ЗГДҮЦ-ны хуваарилалтыг хийхдээ Сангийн сайдын тушаалаар баталсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үнэ, өгөөж, хүү тооцох болон арилжааны хуваарилалт хийх, Засгийн газрын дотоод үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авах аргачлал”-ыг баримтална.

Жишээ 1- Ялгавартай үнэтэй арилжааны хэлбэр



Жишээ 2- Нэгдсэн үнэтэй арилжааны хэлбэр



Зургаа. Төлбөр тооцоо

- Хөрөнгө оруулагч нь ЗГДҮЦ-ны төлбөрийг арилжааны шимтгэлийн хамт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэлтэй өөрийн нэрийн дансанд урьдчилан байршуулснаар арилжаанд оролцно.
- Хөрөнгө оруулагчаас авах арилжааны шимтгэлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Арилжааны журам”-ын нэгдүгээр хавсралтад заасны дагуу тооцож авна.

Долоо. Бусад

- ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны үр дүнг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн www.mse.mn цахим хуудсаар дамжуулан арилжаа явагдсан өдөр бүр олон нийтэд тогтмол хүргэнэ.
- ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаатай холбогдон гарсан аливаа санал гомдлыг энэхүү заавар болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Хяналт, шалгалтын журам”-ын дагуу шийдвэрлэнэ.